



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 456

Улаанбаатар хот

“Бодь даатгал” ХХК-ийн хувь
нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, Компанийн тухай хуулийн 31.2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгч “Бодь Интернэшнл” ХХК-ийн өмчлөлийн нэг ширхэг нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн үнэ бүхий 600,163 /зургаан зуун мянга нэг зуун жаран гурав/ ширхэг буюу 600,162,600.0 / зургаан зуун сая нэг зуун жаран хоёр мянга зургаан зуу/ төгрөгийн хувьцааг иргэн Лувсанвандангийн Болдод худалдаж, компанийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж дараахь байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Л.Болдхуяг	1,400,380,400.0	0.0	1,400,380,400.0	70,0
2	“Бодь Интернэшнл” ХХК	600,162,600.0	(600,162,600.0)	0.0	0,0
3	Л. Болд	0.0	600,162,600.0	600,162,600.0	30,0
	Нийт	2,000,543,000.0	0.0	2,000,543,000.0	100,00

2. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Бодь даатгал” ХХК /Б.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



00 787